



МОНГОЛЫН АВТОЗАМЧДЫН  
ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ З.БАТБАЯР  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251  
Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15,  
Цахим шуудан: info@mrtd.gov.mn,  
Цахим хуудас: www.mrtd.gov.mn

2024. 05. 00 № 00/0003  
танай -ны № -т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Зам, тээврийн хөгжлийн яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, МҮЭ, МАОЭНХ, Нийслэлийн авто замын хөгжлийн газар, "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын төлөөллийн оролцоотойгоор Монголын авто замчдын холбоо, Монголын авто замчдын ҮЭ-ийн холбооноос санаачлан зохион байгуулсан "Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд эрүүл, аюулгүй хөдөлмөр эрхэлцгээ" уриан дор авто замын салбарын "Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аян-2024" чуулга, уулзалтын мөрөөр гарсан зөвлөмжийг хүргүүлж байна.

Авто замын салбарын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн орчныг сайжруулахын хамтаар, зөвлөмжид туссан асуудлыг нэгтгэн зохион байгуулж, тайланг 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлж, хамтран ажиллана уу.

Хавсралт 2 хуудастай:

ДЭД САЙД, ЗАМ, ТЭЭВРИЙН  
САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ  
БАЙDAL, ЭРҮҮЛ АХУЙН САЛБАР ХОРООНЫ  
ДАРГА

Л.ХАЛТАР

9020050420 5919487 СБА7589

000003644

**АВТО ЗАМЫН САЛБАРЫН “ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ  
БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙН САРЫН АЯН-2024 ОН” СЭДЭВТ  
ЧУУЛГА, УУЛЗАЛТААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ**

2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

Зам, тээврийн хөгжлийн яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, МҮЭ, МАОЭНХ, Нийслэлийн авто замын хөгжлийн газар, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын төлөөллийн оролцоотойгоор Монголын авто замчдын холбоо, Монголын авто замчдын ҮЭ-ийн холбоноос санаачлан зохион байгуулсан “**Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд эрүүл, аюулгүй хөдөлмөр эрхэлцгээ**” уриан дор авто замын салбарын “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аян-2024” чуулга уулзалтад авто замын салбарын нийт 200 орчим төлөөлөгчид оролцож, салбарын нийт аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, дарга, захирал, ХАБЭА-н ажилтан, ажилтануудад хандан дараах зөвлөмжийг санал нэгтэй гарган хүргүүлж байна. Үүнд:

1. Зам, тээврийн сайд, Хөдөлмөрийн сайдын 2016 оны “Авто замын салбарын дүрэм батлах тухай”182/A195 дугаар хамтарсан тушаалаар баталсан авто замын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийг бүх аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болоод үйлдвэрлэлийн нэгж, ажлын байр бүрт мөрдөж ажиллах;
2. Шинэчилэн найруулж батлагдсан Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн хөдөлмөрийн гэрээ, ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтод ажилтан аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангах, хамгаалах үүрэг, хариуцлагатай болохыг тусгасан тусгай бүлэг нэмж дээрх бүх баримт бичгийг шинэчлэн байгуулах арга хэмжээг салбарын хэмжээнд зохион байгуулах;
3. Авто замын салбарын ХАБЭА-н бүх шатны инженер техникийн ажилтануудыг аюулгүй ажиллагааны чиглэлээр мэргэшүүлэх арга хэмжээг салбарын хэмжээнд эрчимтэй зохион байгуулж, Авто замын салбарын мэргэшсэн ХАБЭА хариуцсан ажилтны цалинг нэмэгдүүлэх, ажлын үр дүнтэй холбогдсон нэмэлт урамшуулалт олгож ажиллах;
4. Авто замын салбарын ямар ч ажлын байранд нэн ялангуяа орон нутагт ажиллаж буй байгууллагууд бүх шатны ажлын байранд аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдаагүй, зааварчилгаа аваагүй, эрүүл мэндийн үзлэгт ороогүй, мэргэжлийн ур чадваргүй хүнээр ажил, үүрэг гүйцэтгүүлэхгүй байх;
5. Авто замын салбарын хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөлөөс хамаарч эрүүл мэндэд сөрөг нөлөө үүсч болзошгүй ажлын байруудад /гадаа, доргионтой, дуу чимээ....../ ажиллаж байгаа ажилтныг хамгаалах судалгаа хийж, төлөвлөгөө боловсруулах, нийт ажилтныг өртөж болзошгүй үер, ус, бороо, цас, шуурганаас урьдчилан хамгаалах арга хэмжээ авах, ийм тохиолдолд ажилтан хамт олноо бэлэн байлгах сургалт зохион байгуулах, мэдээлэл өгөх арга хэмжээг байгууллага бүр авч хэрэгжүүлэх;
6. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтнуудын эрүүл мэндэд онцгой анхаарал хандуулж, нийт ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулж, үзлэгийн дүнг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, тайланг гаргах;

7. Зөвлөх болон гүйцэтгэгч компаниуд зам, барилгын ажлын явцад Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн сахин биелүүлж, ХАБЭА-н болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр ажиллах ажилтнуудыг мэргэшүүлж, аюулгүй байдлын талаар хүлээх үүрэг, хариуцлагыг шинэчлэн, тодорхой болгох;

8. Үндсэн болон туслан гүйцэтгэгч компанийн ХАБЭА-н жилийн төлөвлөгөө, ХАБЭА-н сургалтын төлөвлөгөө, Галын аюулгүй байдлын журам, төлөвлөгөө, Замын аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө, Онцгой байдалд бэлэн байх, хариу арга хэмжээ авах журмын мөрдүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд Зөвлөх компанийн зүгээс тавих хяналтыг нэмэгдүүлж, тэргүүн ээлжинд ХАБЭА-д анхаардаг болгох;

9. Ажилтан бүр ажлын байран дээр өөрийгээ болон бусдыг аюул эрсдэлд учруулахгүй ажиллах, байгууллагын удирдлагууд нийт ажилтнуудыг ажилдаа ирж очих, ажлын байр, нэгж, хэсэг, салбар хооронд бүх төрлийн тээврийн хэрэгсэл, ердийн хөсгөөр болон явган явах үед аливаа осол зөрчилд өртуүлэхгүй байхад анхаарч, өртсөн тохиолдолд Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комиссын хурлаар хэлэлцэж, шийдвэрлэх;

10. Зам, барилгын ажлын үед авто замын тэмдэг тэмдэглэгээ, тусгаарлагчийг стандартын дагуу байрлуулж, ажилтнууд болон замын хөдөлгөөнд оролцогч, зам дээр ажил үүргээ гүйцэтгэж байгаа ажилтан осол, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх тэмдэг, тэмдэглэгээнд илүү анхаарал хандуулах;

11. Авто замын салбарын хэмжээнд ХАБЭА-н сургалтыг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/173 дугаар тушаалын дагуу зохион байгуулах бөгөөд сургалтын байгууллагын хөтөлбөр, төлөвлөгөөнд Авто замын тухай болон Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хууль тогтоомжийг ХАБЭА-н хууль тогтоомжтой уялдуулан тусгаж, зам, барилгын ажлын онцлогт нийцүүлэн нийт ажилтанд чанартай, хүртээмжтэй мэдлэг эзэмшүүлэх;

12. ХАБЭА-н сургалт зохион байгуулах сургалтын байгууллагын хүлээх үүрэг, хариуцлагыг гэрээнд тодорхой нэмж тусгах байдлаар байгууллагын дарга, удирдлага ХАБЭА-н сургалтыг чанартай зохион байгуулж, хүртээмжтэй мэдлэг олгосон эсэхэд хяналт тавин ажиллах;

13. Байгууллагын дарга, удирдлага ХАБЭА-н хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хариуцан биелүүлж, аюулгүй ажиллагааны гурван шатны хяналтын үзлэгийг зохион байгуулж, чанар үр дүнг сайжруулах, үзлэгийг ажилтан, ажлын байранд түлхүү чиглүүлж, ажилтан аюулгүй ажиллагааны талаар өөрийн үүрэг, хариуцлагаа бүрэн хүлээж ажиллах ур чадвар эзэмшсэн эсэхэд чиглүүлэх;

14. Аж ахуйн нэгж байгууллагууд ХАБЭА-н хуулийн хэрэгжилттэй холбоотой сар тутмын “тоон мэдээлэл”-ийг цахим хэлбэрээр /google.drive/, Зам, тээврийн салбарын ХАБЭА-н салбар хорооны төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас жил тутамд гарган, тайлагнаж, хэвших.

**ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН  
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН САЛБАР ХОРОО**